



## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

### Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6, 66.1.10 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.1.5.г дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах зорилгоор дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг нийт Төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасгай.

1.1. Төрийн албан хаагчдын монгол бичгийн түвшин тодорхойлох судалгааны дүнд үндэслэн харьяалах төрийн байгууллагын албан хаагчийн монгол бичгийн чадварыг сайжруулах сургалтыг боловсролын сургалтын байгууллага, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрийн дагуу үе шаттай зохион байгуулах;

1.2. Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгээс боловсруулсан цахим “Монгол бичгийн гарын авлага”-ыг байгууллагын албан хаагч нэг бүрд таниулах, сургалт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

1.3. Төрийн албан хаагчийн жилийн ажлын төлөвлөгөөнд монгол бичгийн ур чадвараа дээшлүүлсэн болон албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах чадварын асуудлыг тусган гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэх;

1.4. Архивын ерөнхий газартай хамтран байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан нарыг төрийн албан хэргийг хос бичгээр явуулах мэргэжлийн өндөр түвшний ур чадвартай болгох сургалт зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авах;

1.5. Хууль, тогтоол хэрэгжүүлэх, тайлагнах чиг үүргийг байгууллагын захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгжийн даргад хариуцуулж, тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргах.

2. Төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж, шаардагдах зардлыг төсвийн хүрээнд шийдвэрлэх, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөсүгэй.

24000387

3. Тогтоолын хэрэгжилтийг салбар, харьяалах байгууллагын хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийн явцын мэдээллийг 2024 оны 07, 10 дугаар сард багтаан, жилийн тайланг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг Ерөнхийлөгчийн Тамгын газар /Я.Содбаатар/, Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга /С.Батбаатар/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга /Д.Батбаатар/, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтулга/-д тус тус зөвлөсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Б.Пүрэвдагва нарт даалгасугай.

ДАРГА



Ц.ЦЭДЭВСҮРЭН